

2017-2018 ОНЫ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 9 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ГССҮТ, СЭМҮТ, НЭМГ, УАУТ/ мэдээг нэгтгэв.

Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

Амбулаторийн хүлээгдэл 2017 онд 6156 хүлээгдэлтэй байсан бол, 2018 онд 4705, өдөртөө үйлчлүүлсэн 8527 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. УНТЭ /2293/ хамгийн их амбулаторийн хүлээгдэлтэй байна. Нийт хүлээгдлийн 48.7%-ийг эзэлж байна.



Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн кабинет нь УНТЭ-ийн ХБЭСК /603/, хэрх үе судлалын кабинет /338/, мэдрэлийн кабинет /338/, УГТЭ-ийн мэдрэлийн мэс заслын кабинет /303/ байна.

Эмнэлгүүдийн 2018 оны амбулаторийн хүлээгдлийг дүрслэлээр харуулбал:



УНТЭ 2017 онд нийт 747 үйлчлүүлэгч, 2018 онд 2293 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Хамгийн их хүлээгдэл хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 603, үе судлалын кабинетэд 338, мэдрэлийн кабинетэд 338, зүрх судасны кабинет 243 хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн амбулаторийн үйлчилгээ, хүлээгдэлийн тоо

№	Кабинетийн нэр	2017	2018	Нийт
1	Мэс засал	1	31	32
2	Нүд	215	101	316
3	Булчирхай	11	10	21
4	Урологи	45	305	350
5	Мэдрэл судлал	161	338	499
6	Хоол боловсруулах эрхтэн судлал	9	603	612
7	Үе судлал	89	338	427
8	Бөөрний кабинет	6	13	19
9	Зүрх судасны кабинет	12	243	255
10	Уушгины кабинет	11	14	25
11	Чих хамар хоолой	4	23	27
12	Харшил судлал	25	0	25
13	Булчирхайн мэс засал		19	19
14	Нүдний даралт	36	165	201
15	Элэг цөсний мэс засал	39	0	39
16	Шүд	83	1	84
17	Цус судлал		8	8
18	Үений мэс засал		63	63

19	Эрүү нүүрний мэс засал		17	17
20	Судасны мэс засал		1	1
21	Бүгд	747	2293	3040

УХТЭ-т 2017 онд нийт үйлчлүүлэгч, 2018 онд 3154 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Хамгийн их хүлээгдэл хоол боловсруулах эрхтэн судлал, мэдрэл судлал, зүрх судасны кабинетэд бүргэгдсэн байна.

УХТЭ-ийн амбулаторийн үйлчилгээ, хүлээгдэлийн тоо

№	Кабинетийн нэр	2017	2018	Нийт
1	Мэс засал	65	21	86
2	Нүд	36	21	57
3	Булчирхай	69	109	178
4	Урологи	33	3	36
5	Мэдрэл судлал	94	129	223
6	Хоол боловсруулах эрхтэн судлал	228	207	435
7	Бөөрний кабинет	95	55	150
8	Зүрх судасны кабинет	117	203	320
9	Уушгины кабинет	58	31	89
10	Чих хамар хоолой	56	10	66
11	Эмэгтэйчүүд	47	49	96
12	Бүгд	898	838	1736


УГТЭ-т нийт 2017 онд нийт 605 үйлчлүүлэгч, 2018 онд 229 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Хамгийн их хүлээгдэл зүрх судасны кабинетэд бүргэгдсэн байна.

УГТЭ-ийн амбулаторийн үйлчилгээ, хүлээгдэлийн тоо


№	Кабинетийн нэр	2017	2018	Нийт
1	Нүд	26	0	26
2	Урологи	15	0	15
3	Мэдрэл судлал	55	0	55
4	Хоол боловсруулах эрхтэн судлал	68	0	68
5	Бөөрний кабинет	22	0	22
6	Зүрх судасны кабинет	96	229	325
7	Уушгины кабинет	13	0	13
8	Зүрхний мэс засал	295	0	295
9	Уламжлал	15	0	15
10	Бүгд	605	229	834

2017 онд ХСҮТ-ийн амбулаторийн 11 кабинетэд нийт 3906 үйлчлүүлэгчдэд хүлээгдэлтэй үйлчилсэн байна.


ХСҮТ-ийн 2017 оны амбулаторийн үйлчилгээ, хүлээгдэлийн тоо



2018 онд ХСҮТ-ийн амбулаторийн 12 кабинетэд 1155 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.



2017 онд ЭХЭМҮТ-ийн амбулаторийн хүлээгдэл байхгүй, 2018 онд 2 кабинетэд 190 хүлээгдэл бүртгэгдсэн байна.



Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2017 онд УНТЭ 1787, УХТЭ 826, УГТЭ 1179, ХСҮТ 2526 үйлчлүүлэгчийн хүлээгдэл оношлогооны кабинетэд бүртгэгдсэн байна. Үүнээс ХСҮТ-ийн рентген 1056, УХТЭ-ийн эхоний кабинет 338, УГТЭ-ийн эхоны кабинет 490, ХСҮТ-ийн эхо 532 ХСҮТ-ийн бүдүүн гэдэсний дуран 732, УНТЭ-ийн уушигны дуран 936 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь хамгийн олон үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн үзүүлэлт байна.

2017 оны төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл, үзлэгийн төрөл

№	Үзлэгийн кабинетын нэр	УХТЭ	УГТЭ	УНТЭ	ХСҮТ
1	Рентген зураг	151	179		1056
2	Зүрхний цахилгаан бичлэг	168	167	68	
3	Эхо	338	490	165	532
4	Эндоскопи	75	116	125	206
5	Холтер	2	5	22	
6	Тархины цахилгаан бичлэг	0	54	5	
7	Допплеро-графи	37	125	11	
8	Эмгэг сэтгэл судлал				
9	Аудиграмм	2			
10	Нүдний уг харах	50			
11	MRI/CT	3			
12	Захын судасны эхо			45	
13	Радио-иммунологи			307	
14	Бүдүүн гэдэсний дуран				732
15	Зүрхний эхо		43	78	
16	Зүрхний ачаалалтай сорил			14	

17	Бамбайн эхо			3	
18	Сонсголын бичлэг			3	
19	Уушигны дуран			936	
20	Маммаграфи			5	
21	Бүгд	826	1179	1787	2526

2018 онд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооний 24 кабинетед 8876 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнээс УНТЭ-ийн рентген 920, УНТЭ эхо 950, УХТЭ-ийн рентген 860, УХТЭ-ийн эхо 654, УГТЭ-ийн 631 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

2018 онд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл, үзлэгийн төрөл

№	Үзлэгийн кабинетын нэр	УХТЭ	УГТЭ	УНТЭ	ХСҮТ
1	Рентген зураг	860	238	920	363
2	Зүрхний цахилгаан бичлэг	491	571	39	
3	Эхо	654	631	950	563
4	Эндоскопи	266	34		105
5	Холтер	16	27		
6	Тархины цахилгаан бичлэг	4	80	62	
7	Допплеро-графи	116	113	11	
8	Эмгэг сэтгэл судлал				
9	Аудиграмм				
10	Нүдний уг харах	81			
11	MRI/CT	24		208	194
12	Захын судасны эхо			125	
13	Радио-иммунологи			350	
14	Бүдүүн гэдэсний дуран			97	27
15	Зүрхний эхо		70	1	
16	Зүрхний ачаалалтай сорил				
17	Бамбайн эхо				
18	Сонсголын бичлэг			2	
19	Уушигны дуран				103
20	Маммаграфи				479
21	Бүгд	2512	1764	2765	1834

СЭСҮТ-д 2017 онд эмгэг сэтгэл судлалын кабинетийн оношлогоонд нийт 649 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнээс 3-6 хоногоор хүлээсэн үйлчлүүлэгчийн тоо хамгийн их байна. СЭМҮТ-д 2018 онд эмгэг сэтгэл судлалын кабинетийн оношлогоонд нийт 1221 үйлчлүүлэгийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн 2017, 2018 онд сэтгэл судлалын кабинетийн хүлээгдлийн тоо, хоног



Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2017 онд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 8 төрлийн лабораторийн шинжилгээг хийлгэхээр 14995 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд УНТЭ-д лабораторийн шинжилгээний хүлээгдэл мэдээлэгдээгүй. УХТЭ 9135, УГТЭ 5350, УНТЭ 510 лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлжээ.

2018 онд лабораторийн шинжилгээнд 3124 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд: УНТЭ лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэлгүй байна. Хамгийн их хүлээгдэл 2018 онд УХТЭ-ийн биохимийн шинжилгээнд 1605, УГТЭ-ийн биохимийн шинжилгээнд 400 хүлээгдэл бүртгэгдсэн байна.

2017 оны төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдлийн тоо, шинжилгээний төрөл

2018 онд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдлийн тоо, шинжилгээний төрөл

№	Үзүүлэлт	УХТЭ	УГТЭ	УНТЭ	УХТЭ	УГТЭ
		2017 он			2018 он	
1	Цусны шинжилгээ	985	1445	306	227	282
2	Шээсний шинжилгээ	789	552	131	192	0
3	Биохими	5902	1673	51	1605	400
4	Бактерлоги	441	494	21		
5	Иммунологи	590	657	1	268	2
6	Серологи	151	231		32	
7	Цитологи	94			17	
8	Коагулограмм	183	298		76	23
9	Нийт	9135	5350	510	2417	707

Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2017 онд УНТЭ 306, УХТЭ1437, УГТЭ 1376 үйлчлүүлэгч тусламж үйлчилгээний 9 чиглэлээр хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдсэн нь бүртгэгдсэн байна. УХТЭ-д мэс засал 405, УГТЭ зүрх судас 342, мэдрэлийн мэс заслын чиглэлээр хэвтэн эмчлүүлэхээр 331 үйлчлүүлэгч хүлээсэн байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

2018 онд УГТЭ-ийн мэдрэлийн мэс заслын тасагт 660, УХТЭ-ийн мэс заслыг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 572 үйлчлүүлэгч хүлээсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

2017 оны төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл, тусламж үйлчилгээний төрөл

№	Тусламж үйлчилгээний төрөл	УХТЭ	УГТЭ	УНТЭ
1	Бөөр судлалын тасаг	77	74	9
2	Зүрх судасны кабинет	240	342	11
3	Уушгины кабинет	88	83	171
4	Мэс заслын кабинет	405	28	4
5	Мэдрэлийн кабинет	185	92	8
6	Нүдний кабинет		76	4
4	Чих хамар хоолой	68	214	26

2018 онд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл, тусламж үйлчилгээний төрөл

№	Тусламж үйлчилгээний нэр	УГТЭ	УХТЭ	УНТЭ
1	Бөөр судлалын тасаг	30	55	
2	Зүрх судасны тасаг	73	219	
3	Уушгины кабинет	44	36	5
4	Мэс заслын тасаг	10	777	
5	Мэдрэлийн тасаг	86	68	
6	Нүдний тасаг	16		


5	Уламжлалт эмчилгээний кабинет	132	4	2
6	Урологи			18
7	Хоол боловсруулах эрхтэн судлал	242	132	13
8	Мэдрэлийн мэс засал		331	
9	Дотоод шүүрэл			40
10	Нийт	1437	1376	306

7	Чих хамар хоолойн тасаг	335		61
8	Уламжлалт эмчилгээний тасаг	1	71	
	Урологийн тасаг			27
9	Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг	45	158	7
10	Мэдрэлийн мэс засал	638		3
11	Нийт	1278	1384	100

2017 онд УАУТХ-ийн уламжлалт эмчилгээний тасаг нийт 1037 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээсэн байна. 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 291 үйлчлүүлэгч, 3-6 хоног 206 үйлчлүүлэгч, 7-14 хоног 300 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хугацаанд 183 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хугацаатайгаар 57 үйлчлүүлэгчийн хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

2018 онд УАУТХ-ийн уламжлалт эмчилгээний тасаг нийт 870 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээсэн байна. 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 158 үйлчлүүлэгч, 3-6 хоног 140 үйлчлүүлэгч, 7-14 хоног 295 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хугацаанд 277 үйлчлүүлэгчийн хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

2017, 2018 онд УАУТХ-ийн уламжлалт эмчилгээний тасгийн хүлээгдэл, хоногоор



СЭМҮТ-ийн Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасгийн хүлээгдэл 2017 онд 1109 байсан бол 2018 онд 1572 байна.

СЭМҮТ-ийн Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасгийн хүлээгдэл /2017,2018 он/




ЭХЭМҮТ-ийн эрсдэлтэй жирэмсэн судлалын тасаг 2017 онд 4, 2018 оны хүлээгдэл 4 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасагт хэвтүүлэн эмчлүүлэхээр 2017 онд 2 хүлээгдэл, 2018 онд хүлээгдэл 0 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.

Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2017 онд НЭМГ-ын харьяа 7 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн дотор 908, ахмадын эмчилгээ 728, мэдрэл 594, Хан-Уул дүүргийн дотор 844, 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2017 оны хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэл, эмнэлэг, тусламж үйлчилгээний төрөл



2018 онд НЭМГ-ын харьяа 7 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн дотор 1323, ХУД-ийн дотрын тасагт 613 үйлчлүүлэгч 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.


Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэл, эмнэлэг, тусламж үйлчилгээний төрөл

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хүлээгдлийн мэдээ-2018 оны								Нийт дүн
			СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	Нарк олог ийн эмнэлэг	
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	638	110	2	86	274	289	0	0	1399
		1-3 хоног	37	53	13	36	0	29	0	0	168
		3-6 хоног	87	84	2	34	57	105	0	0	369
		7-14хоног	193	26	0	48	99	149	0	0	515
		15-30 хоног	269	0	0	4	118	35	0	0	426
		1 сараас дээш	89	0	0	0	0	0	0	0	89
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	132	613	542	442	72	374	69	0	3435

		1-3 хоног	71	181	477	136	0	61	67	0	993	
		3-6 хоног	127	215	273	136	49	78	37	0	915	
		7-14хоног	433	185	168	155	23	243	19	0	1226	
		15-30 хоног	527	32	101	147	0	53	13	0	873	
		1 сараас дээш	236	0	0	4	0	0	0	0	240	
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	493	0	0	0	0	95	0	0	0	588
		1-3 хоног	157	0	0	0	0	101	0	0	0	258
		3-6 хоног	275	0	0	0	0	80	0	0	0	355
		7-14хоног	176	0	0	0	0	15	0	0	0	191
		15-30 хоног	42	0	0	0	0	0	0	0	0	42
		1 сараас дээш	0	0	0	0	0	0	0	0	0	0
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	82	0	0	0	0	0	82
		1-3 хоног	0	0	0	23	0	0	0	0	0	23
		3-6 хоног	0	0	0	28	0	0	0	0	0	28
		7-14хоног	0	0	0	37	0	0	0	0	0	37
		15-30 хоног	0	0	0	17	0	0	0	0	0	17
		1 сараас дээш	0	0	0	0	0	0	0	0	0	0
7	Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо									817	817
		1-3 хоног									331	331
		3-6 хоног									522	522
		7-14хоног									227	227
		15-30 хоног									53	53

Нийслэлийн ЭМГ-ийн харьяа Наркологийн төвд 2017онд 1278 үйлчлүүлэгч 1-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна. 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 241 үйлчлүүлэгч, 3-6 хоног 298 үйлчлүүлэгч, 7-14 хоног 78 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хугацаанд 22 үйлчлүүлэгчийн хүлээгдэлд бүртгэгджээ.


Нийслэлийн ЭМГ-ийн харьяа Наркологийн төвийн 2017оны Наркологийн тусламж үйлчилгээ, сар, хоног



2018 онд 817 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. 3-6 хоног 522 үйлчлүүлэгч, 7-14 хоног 227 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хугацаанд 53 үйлчлүүлэгч, 1 сараас дээш 15 үйлчлүүлэгчийн хүлээгдэлд бүртгэгджээ.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2017 онд нийт 292675 дуудлага бүртгэгдсэний 30.5 %-ийг 0-20 минутад, 30.7 %-ийг 21-40 минутад, 20.2%-ийг 41-60 минутад, 17.5 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

2017 оны Нийслэлийн түргэн тусламжийн төвд ирсэн дуудлагад хүрч үйлчилсэн хугацаа хувь, хугацаа



2018 онд Нийслэлийн түргэн тусламжийн төвд нийт 307417 дуудлага бүртгэгдсэний 37.65 %-ийг 0-20 минутад, 30.9 %-ийг 21-40 минутад, 17.5%-ийг 41-60 минутад, 13.9 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА